



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит зарим байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, нийт 164,706,708.68 (нэг зуун жаран дөрвөн сая долоон зуун зургаан мянга долоон зуун найман төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн балансын үнэ 123,258,074.03 (нэг зуун хорин гурван сая хоёр зуун тавин найман мянга далан дөрвөн төгрөг гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Тогтоолын хавсралтад заасан төрийн өмчит байгууллагын дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, үнэ шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашины төлбөр хураамжийг бүрэн төлж, автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001371

15-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн
263 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэр-лэсэн/Ашиг-лалтад орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Хүлээлгэн өгсөн байгууллагын нэр
1	Прокурорын ерөнхий газар	Ниссан тина	06-51 УБҮ	JN1BAUJ32Z000 0624	2011/2012	12,580,000.00	524,166.59	12,055,833.41	"Хархорин АЗЗА" ТӨХК
2	Иргэний нисэхийн ерөнхий газар	Ниссан Патрол Y-61	83-99 ХОҮ	JN1TCSY61Z057 9529	2010/2011	20,000,000.00	-	20,000,000.00	Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний 256 дугаар анги
3	Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар	Хьюндай Соната-6	07-22 УБЗ	KMHET41AP9A5 71754	2008/2008	5,375,000.00	5,375,000.00	-	Монгол Улсын их сургуулийн харьяа Шинжлэх ухаан технологийн Улаанбаатар парк
4	"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	Тоёота Ланд круйзер 200	2089УНУ	JTMHJ09J6B50 41970	2011/2011	126,751,708.68	117,358,907.44	9,392,801.24	"Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК
Нийт дүн									
						164,706,708.68	123,258,074.03	41,448,634.65	
						(нэг зуун жаран дөрвөн сая долоон зуун зургаан мянга долоон зуун найман мянга далан дөрвөн төгрөг гурван мөнгө)	(нэг зуун хорин гурван сая хоёр зуун тавин найман мянга далан дөрвөн төгрөг гурван мөнгө)	(дөчин нэгэн сая дөрвөн зуун дөчин найман мянга зургаан зуун гучин дөрвөн төгрөг жаран таван мөнгө)	